




**2023 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ, ДАГАЛДАХ
ХУУЛИУДЫН ТӨСӨЛД ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ
БАЙДЛЫН ЗӨВЛӨЛӨӨС ӨГСӨН ЗӨВЛӨМЖ**

2022.10.19

АГУУЛГА

- **Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн бүрэн эрх**
- **Төсвийг дэмжих эдийн засгийн нөхцөл байдал**
- **Төсвийн тогтвортой байдлын тухай хууль**
- **Төсвийн төсөлд өгсөн зөвлөмж**



Улсын Их Хурлын 2017 оны 12 дугаар сарын 22-ны 83 дугаар тогтоолоор Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийг байгуулж, 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн ажиллаж эхэлсэн.

Зөвлөлийн бүрэн эрх:

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр сарын 14-ний 69 дүгээр тогтоолын 3 дугаар зүйлд:

- Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилт;
- Жилийн болон дунд хугацааны төсвийн төсөлд дүгнэлт гаргах;
- Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөлд дүгнэлт гаргах;
- Төсөвт нөлөөтэй хууль тогтоомжийн төсөлд дүгнэлт гаргах;
- Энэхүү бүрэн эрхийн хүрээнд ТТБЗ өөрсдийн санал дүгнэлтийг УИХ-ын гишүүд, улмаар олон нийтэд танилцуулж, тэдний санал дэмжлэгийг авах эрх зүйн зохицуулалттай. Сонин, телевиз, УИХ-ын мэдээллийн сайт зэргийг ашиглаж байна. Зөвлөлийн санал дүгнэлт улс төрөөс ангид, бие даасан, агуулга нь чанартай, хүртээмжтэй байх учиртай билээ.

Бүрэлдэхүүн:

- Орон тооны бус 9 гишүүнтэй зөвлөл

*Дээрх бүрэн эрхийнхээ дагуу Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс
2022 оны 10 дугаар сарын 06-ны өдөр 2023 оны төсвийн төсөлд
зөвлөмж өгсөн.*

Төсөвт нааштай нөлөө үзүүлэх арга хэмжээ

- ✓ Тавантолгой-Гашуун сухайт (239 км), Тавантолгой Зүүнбаянгийн (416 км), Зүүнбаян-Ханги (226 км) нийтдээ **881 километр төмөр зам** энэ онд шинээр ашиглалтад орно.
- ✓ Засгийн газар Олон улсын хэмжээнд худалдаа арилжаа, төлбөр тооцоог хэвийн явуулах, нүүрсний экспортыг нэмэгдүүлэх, эрчим хүч, бензин шатахууны хангамжийг баталгаажуулах боломжийг ханган ажиллаж байна.
- ✓ Манай орны эдийн засгийн амьдралыг голлон шийддэг таваарын бүтээгдэхүүний үнэ, эрэлт, нийлүүлэлт дэлхийн голлох эдийн засагтай орнуудын нөхцөл байдлаас ихээхэн хамаардаг.
- ✓ Хүнсний зарим бараа, бензин шатахууны нөөц бүрдүүлэхэд Засгийн газраас хүүний хөнгөлөлт үзүүлж, Монголбанкнаас санхүүгийн эх үүсвэр бүрдүүлж байна. Монголын хүний амин чухал хэрэгцээ болсон **гурил, махыг манай хөдөө аж ахуйн салбар, хангах боломж бүрдэхээр байна.**

Сая ам.доллар

Түүхий эд	Хэмжих нэгж	Үнэ		
		2021.10.14	2022.10.14	Өөрчлөлт
Зэсийн баяжмалын үнэ /Лондонгийн металлын бирж/	Ам.доллар/тонн	9,971.0	7,688.0	-22.9 %
Коксжих нүүрсний үнэ /БНХАУ-ын зах зээлд худалдаалагдаж буй сайн чанарын коксжих нүүрс/	Ам.доллар/тонн	419.0	348.0	-16.9 %
Төмрийн хүдрийн үнэ /62%-ийн агууламжтай/	Ам.доллар/тонн	125.2	92.9	-25.7 %
Алтны ханш	Ам.доллар/унц	1,795.9	1,655.3	-7.8 %
Түүхий нефтийн үнэ /Вест техас брендийн/	Ам.доллар/баррель	81.3	85.6	5.3 %

Барааны нэр	Хэмж их нэгж	Экспорт /Сая ам.доллар/					
		2021 оны эхний 9 сар			2022 оны эхний 9 сар		
		Тоо	Үнэ	Хувь	Тоо	Үнэ	Хувь
Нийт экспорт			6,404.7	100%		8,919.6	100%
Чулуун нүүрс	1000 тн	11,989.5	1,501.6	23%	19,018.7	4,505.8	50.5%
Зэсийн хүдэр, баяжмал.	1000 тн	1,020.9	2,307.3	36%	1,093.4	2,175.2	24.4%
Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт	кг	7,873.6	460.0	7%	12,867.4	749.4	8.4%
Төмрийн хүдэр, баяжмал	1000 тн	5,947.7	847.8	13%	3,199.6	291.5	3.3%
Нийт экспортод эзлэх хувь			5,116.7	79.9%		7,721.9	86.6%

- ✓ Зэсийн баяжмалын үнэ бууралттай байна.
- ✓ Бууралт богино хугацаанд ажиглагдаж цаашид өсөх, тогтворжих төсөөллийг ихэнх эдийн засагчид дэвшүүлж байна.

- ✓ Нүүрсний экспорт нийт үнийн дүнгээр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3 Дахин өсөж 4,505.8 сая ам.долларын экспортын орлогыг бүрдүүлсэн байна.

Эрсдэл

- Монголын хүн амын амьдрал, төсөв, эдийн засагт онцгой нөлөөтэй нефть бүтээгдэхүүний хангамж, үнийг тогтворжуулах талаарх төр засгийн хүчин чармайлтыг дэмжиж байна. Өнөөгийн эгзэгтэй, тодорхойгүй нөхцөлд эдгээр төрлийн бүтээгдэхүүний нийлүүлэлтэд онцгой анхаарч улс төр, эдийн засаг, дипломат ажиллагаа, гадаад худалдааны бодлогод туйлын ухаалаг болгоомжтой хандах учиртай юм.

Нефтийн бүтээгдэхүүн	Импорт /Тонн, сая ам.доллар/			
	2021 оны эхний 9 сар		2022 оны эхний 9 сар	
	Тоо	Үнэ	Тоо	Үнэ
	1,255,641.7	738.4	1,315,467.8	1,228.4


- Олон улсын зах зээл дээрх газрын тос, хүнсний бүтээгдэхүүний үнийн хөөргөдөл, хөрш ОХУ-ын геополитикийн зөрчил, БНХАУ-ын цар тахлын хатуу хорионоос шалтгаалж манай үйлдвэрлэл, нийлүүлэлт, тээвэр, логистикийн тасалдал нэмэгдэж, үнэ ханшийн нөхцөлийг улам ихээр дордууллаа.
- Дотоодын эрэлт, хэрэглээ тэлж инфляцыг хөөрөгдөж, төлбөрийн тэнцэл, валютын ханшид сөрөг нөлөө үзүүлж байна.
- Дэлхий дахинаа валютын ханш савлагаатай байна.

Валютын нэр	2022 он		
	III	VI	IX
Төгрөг	-3.5	-10.0	-17.4
Евро	-4.8	-12.2	-15.3
Японы иен	-9.6	-19.1	-22.5



- Үнийн өсөлт, түүнийг намжаах зорилгоор явуулж эхэлсэн АНУ, Европын орнуудын мөнгөний хязгаарлалтын бодлогын сөрөг үр дагавар нь улс орнуудын эдийн засгийн өсөлтийг 2022, 2023 онд сааруулах хүчин зүйл болж байна.
- Таваарын бүтээгдэхүүний үнэ, ханш буурах төлөв рүү орж байна.
- Газрын тос, байгалийн хийн үнийн тэсрэлт гарах эрсдэл их байна.
- Дэлхийн банкнаас энэ оны 9 дүгээр сарын сүүлчээр Дэлхийн эдийн засгийн өсөлтийн талаарх өмнөх төсөөллийг бууруулсан тоймыг гаргалаа.

ХОЁР. Төсвийг дэмжих эдийн засгийн нөхцөл байдал






- Дэлхий дахинаа эрчим хүч, ялангуяа газрын тос, үр тарианы үнэ энэ оны хавар, зуны улиралд нэмэгдэж, баррель газрын тос 125 ам.доллар, үр тарианы үнэ 2-3 дахин өсөж байсан.
- Дэлхий дахины олон оронд газрын тос, байгалийн хийг нүүрсээр орлуулж, цахилгаан дулаанаа шийдэх төлөвтэй болсон, өнгөрсөн жил БНХАУ-д гарсан эрчим хүчний хямрал зэрэгтэй уялдан нүүрсний эрэлт, үнэ ханш 2-3 дахин өслөө. Бидэнд хамгийн нааштай байсан зүйл бол нүүрсний зах зээл байлаа.

- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль 2010 онд батлагдсан.
- Төсвийн хяналтыг чангатгах 3 зорилт тавьсан.
 - ✓ *Төсвийн алдагдлыг ДНБ-ий 2 хувиас хэтрүүлэхгүй эсвэл ашигтай байлгах;*
 - ✓ *Засгийн газрын өрийг ДНБ-ий 40 хувиас хэтрүүлэхгүй байх;*
 - ✓ *Эрдэс түүхий эдийн үнийн өсөлтийн тодорхой хэсгийг санд хуримтлуулж байх зарчим тогтоосон.*

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл анхаарал хандуулж, хэрэгжилтийг хангуулахаар хүчин чармайлт гарган ажиллаж байна.



ТӨСВИЙН ТЭНЦИЙН ХУВИЙН ЖИН



- 2018, 2019 онд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагуудыг мөрдөж ажилласан боловч цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалж 2020, 2021 онд хуульд өөрчлөлт оруулан тусгай шаардлагуудыг сулруулснаар төсвийн алдагдлыг нэмэгдүүлсэн. Үүний зэрэгцээ Ирээдүй өв сангийн хөрөнгийг хүүхэд зориулж, төсвийн тогтворжуулалтын санг төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд ашиглах болсон. Эдгээр сангуудыг сэргээж, зориулалтын дагуу ашиглах санал тавьж байгаа. Чингэхдээ эрдэс баялгийн ашиглалтаас үүсэх хуримтлалыг иргэдийн мэдэлд шилжүүлэх нь илүү өгөөжтэй гэж дүгнэсэн.
- Төсвийн шалгуурыг өөрчилдөг буруу хандлага тогтлоо. Үүнийг залруулж зогсоох шаардлагатай болохыг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн зүгээс удаа дараа анхааруулж ирсэн.
- Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд төсвийн тусгай шаардлагыг 4 жил тутам хянан үзэж байх, эдийн засгийн өсөлт хасах болсон, томоохон гамшиг буюу өнөөгийн КОВИД-19 цар тахлын хэмжээний зардалтай дүйцэхүйц гамшиг гарвал дээрх 2 төсвийн тусгай шалгуурыг өөрчлөх бус, мөрдөхийг түр түдгэлзүүлэх хуулийн заалттай. Гэтэл энэхүү шалгуурыг өөрчилсөөр байгаа нь Үндсэн хуулийн нэгдүгээр зүйл дэх “хууль дээдлэх” зарчимд нийцэхгүй байна гэж үзэж байна.
- Энэ бүхэн цаашид Үндсэн хуулийн 5 дугаар зүйлд тусгагдсан төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангах зорилтод нийцүүлэн эдийн засгийг зохицуулах тухай асуудлыг хөндөн ярихад хүргэж мэдэхээр байна. Төсвийн алдагдал бол Засгийн газрын өр нэмэгдэх үндсэн шалтгаан бөгөөд өдгөө зээлийн эргэн төлөлт, хүүгийн төлбөр, төсөвт хүндрэл учруулж, нийгмийн арга хэмжээ, хөгжилд зориулах хөрөнгийг хумьж байна. 2023 оны төсөвт Зээлийн хүүний төлбөрт 1,180 тэрбум төгрөг, мөн үүнээс дутахгүй хөрөнгийг гадаад, дотоод зээл, бондын үндсэн төлбөрт зарцуулахаар тусгагдсан байна. Цаашид зээлийг аль болох хязгаарлах нь чухал болсон.

Хууль дээдлэх зарчим чухал

- Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийг жил бүрийн 05 дугаар сард тогтоогоод дараа жилийн төсөв батлах үед өөрчилдөг явдал үргэлжилсээр байна. Тухайлбал 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдөр баталсан Төсвийн төсөөллөөс 2023 оны төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 1.6 их наяд төгрөг, зардлыг 1.3 их наяд төгрөгөөр тус тус нэмэгдүүлжээ.
- Ийнхүү өөрчлөлт оруулж байгаагийн үндэслэлийг судалж, Төсвийн тогтвортой байдлын тухай 2010 оны хуульд заасан эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, төсвийн тоо баримтуудыг 2 ангилж, **заавал мөрдөх болон баримжаа үзүүлэлт** хэлбэрээр ялгаж, олон улсын чиг хандлагын дагуу төсвийн хүрээний мэдэгдлээс дунд хугацааны зардлын хүрээний хязгаар болгон шинэчилж, төсөв захирагчдын үүрэг хариуцлага, эрхийг нэмэгдүүлэх асуудлыг судлах нь зүйтэй гэсэн дүгнэлт гарсан.



ТӨСВИЙН БОДЛОГО

- Өнөөгийн эгзэгтэй мөчид төсөв, мөнгөний зарцуулалтыг чангатгах, хүн амын болон үйлдвэрлэлийн үндсэн хэрэглээний нөөцийг тасалдуулахгүй байх, юмны үнийн өсөлтийг богино хугацаанд намжаах тухай төр, засгийн бодлого, удирдлагуудын хэлсэн ярьсныг Төсвийн тогтвортой байдлын зөвлөл талархан хүлээн авч, тэдгээрийг ажил хэрэг болгоход өөрсдийн санаа бодлыг нэмэрлэхийг зорьж байна.
 - Чингэхдээ бид төсвийн зорилтын хэрэгжилтийг эдийн засаг, бизнесийн үйл ажиллагаа, хувийн хэвшлийн өргөн хэмжээний оролцоо, өгөөж өндөртэй төсөл, хөтөлбөрүүдээр дэмжих.
 - Нөгөө талаас төсөв, түүний бодлого, хэрэгсэл нь эргээд нийт эдийн засгаа дэмжих, мөнгөний бодлогод хүндэтгэлтэй хандах гэсэн нийтлэг үзэл баримтлалыг үндэс болгож байна.
- Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд төмөр зам, цахилгаан эрчим хүч, газрын тосны үйлдвэрлэл, боомтын бүтээн байгуулалт, эрдэс баялгийн ашиглалт, хөнгөн хүнсний үйлдвэрлэлийн экспортод тэргүүн зэргийн ач холбогдол өгч байгаа нь чухал байна.



- Халамжаас хөдөлмөрт гэсэн концепцийг ихэнх иргэд дэмжиж байна гэж ойлгож байна. Халамж, төсвийн дэмжлэгийг зорилтод бүлэгт шилжүүлэх, ажил эрхлүүлэхэд зориулах, хүн амын доторх нийгмийн ялгаварлалыг багасгах, шударга ёсыг бүрдүүлэхэд нийт орлого, **төсвийн хуваарилалтыг оновчтой** болгох чухал байна.
- 2023 оны төсвийн төсөөллөөс үзэхэд бүх төрлийн халамжид 2 их наяд, нийтийн тээвэр, эм урвалж, зарим барааны үнэ тарифын татаас, урамшуулал, хүүхэд, сурагчдын хоол хүнс зэрэгт 0.8 их наяд төгрөг зарцуулж, 0.9 их наяд төгрөгийн татварын хөнгөлөлт үзүүлэх ажээ.
- Төсвийн зардлын зүйл заалтуудад шүүлт хийж, тэвчиж болох зардлыг зогсоох, хувь иргэн, байгууллагын хариуцлагыг төр өөр дээрээ татан авдаг явдлыг хязгаарлах цаг болсон. Хамгийн гол нь дор дурдсан хөрөнгийн багагүй хэсгийг голчлон гадаадаас өндөр хүүтэй, хатуу валютаар төлөгддөг зээлээр төсвийн алдагдлаар дамжуулан санхүүжүүлж байгаад асуудлын сөрөг тал оршиж байна.




ТӨСВИЙН ОРЛОГО



- Нийт орлого ба тусламжийн дүнг **19,594.6 тэрбум төгрөг** байхаар тооцсон байгаа нь ДНБ-ий **35.9** хувьтай тэнцэхээр байна. Энэ нь 2022 оны 2 дахь төсвийн тодотголын дүнгээс **3,316.5 тэрбум төгрөг** буюу 20.4 хувиар өсгөж тооцсон дүн ажээ.

ДӨРӨВ. Төсвийн төсөлд өгсөн зөвлөмж

ТӨСВИЙН ЗАРЛАГА



- Төсвийн нийт зарлага **20,475.3 тэрбум төгрөг** буюу 2022 оны тодотгосон дүнгээс **2,561.8 тэрбум төгрөг** /14.3 хувь/-өөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна. 2023 төсвийн алдагдал 1,553.4 их наяд төгрөг нь 2020 оноос 2,887.0 тэрбум төгрөгөөр, 2021 оноос 1,365.6 тэрбум төгрөгөөр, 2022 оноос 883.7 тэрбум төгрөгөөр тус тус багассан нь сайжирсан үзүүлэлт байна.

Монгол Улсын 2023 оны төсөвтэй холбогдуулан дараах санал, зөвлөмжийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс хүргүүлсэн болохыг толилуулж байна

- 2023 оны төсвийн зардлыг 2022 оны хэмжээнд царцааж, 2023 оны төсвийг алдагдалгүй батлах эсвэл алдагдлын хэмжээгээр хүүхдийн мөнгийг хүүтэйгээр хуримтлах тогтолцоог бий болгох.
- Гадаад, дотоод зах зээлээс хөрөнгө босгоход хүндрэлтэй үнэ ихтэй болж байна.
 1. Дэлхий дахинд болон Монголд инфляц өсөж, зээлийн хүү 2 оронтой тоогоос давах болсон.
 2. Зээлжих зэрэглэлийг хадгалахад төсвийн сахилга батыг мөрдөх нь чухал үзүүлэлт болно.
 3. Монголд төсвийн зардлыг хязгаарлаж инфляцыг багасгах 1 оронтой тоонд оруулах, төлбөрийн тэнцлийн алдагдлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх.
 4. Баялгаа эрчимтэй ашиглах цаг мөчид буюу Оюутолгойн далд уурхайг ашиглаж эхлэх, нүүрсийг их хэмжээгээр экспортлох боломж гарч буй өнөө үед төсвийн алдагдлыг зогсоож, байнга уламжлан **өр тавьдаг явдалд цэг тавих** нь цаг үеэ олсон хэрэг болно.

- Засгийн газрын зээлийн тухайн жилийн графикт төлбөрийн 20-иос доошгүй хувийг төлж, өрийг нэмэгдүүлэхгүй байх.
 1. Засгийн газрын мэдээгээр өрийн хэмжээ анхааруулах түвшинд хүрсэн. Төсвийн алдагдал өөрөө өр зээл нэмэгдүүлнэ.
 2. Дээр дурдсанчлан зээлийн үйлчилгээний төлбөр төсвөөс зайлшгүй санхүүжүүлэх шаардлагатай боловсрол, эрүүл мэнд, тэтгэвэр тэтгэмж зэрэг нийгмийн зардлыг хязгаарлах хүчин зүйл болж байна.
- 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтыг ирэх онд шинэ төсөл, арга хэмжээг төсвөөс санхүүжүүлэхгүйгээр 10-15 жилээр төсвийн хөрөнгийг үр дүнгүй зарцуулдаг дутагдлыг засах, арилгахаар төлөвлөснийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөл бүрэн дэмжиж, зарим дуусаагүй барилга байгууламжийг хувийг хэвшилд худалдах, тэдний мэдэлд шилжүүлэх боломжийг судлууштай.
- Бүх төрлийн орлого, зарлагын бэлэн ба бэлэн бус гүйлгээг заавал бүртгэдэг хууль, эрх зүйн үндсийг бүрдүүлж, улсын нэгдсэн мэдээллийн санд оруулж, иргэд, аж ахуйн нэгж байгууллагын орлого, зарлагын улсын хэмжээний тайлан мэдээлэлтэй болж, хүн амын амьжиргааны түвшинг тогтоож, түүнийг харгалзан нийгмийн бүх төрлийн үйлчилгээ, халамж, тэтгэмж, тэтгэлэг, татварын болон бусад хөнгөлөлтүүдийг олгодог үндсэн хуулийн зарчим, олон улсын жишгийг мөрдүүлэх;



- Гадаадын хөрөнгө оруулалтын ихээхэн хэсэг нь уул уурхайн салбарт, түүний дотор эрдэс түүхий эдийг олборлох, тээвэрлэхэд чиглэсэн байгааг анхааралдаа авч, тэдгээрийг боловсруулах, мөн сэргээгдэх эх үүсвэр болох мал аж ахуй болон нар салхины зэрэг нөөцөд түшиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээнд зориулагдах хөрөнгө оруулалтыг бүх талаар дэмжих арга, механизмыг боловсруулж, нэвтрүүлэх. Үүний тулд экспортын эцсийн бүтээгдэхүүнд татварын нэн таатай орчин бүрдүүлэхэд анхаарах;
- Экспортын үйлдвэрлэлийг дэмжих даатгал, зээлийн баталгаа, татвар, зээлийн хөнгөлөлт санхүүжилтийн хэрэгсэл зэргийг хамарсан иж бүрэн механизм бүрдүүлж хэрэгжүүлсэн байх
- Үндэсний хуримтлал, ажиллах хүчний оролцооны түвшин бусад орнуудтай харьцуулахад нэн доогуур байгаа нь суурь асуудал бөгөөд өр үүсэх үндсэн шалтгаан мөн. Төсөв, мөнгө болон эдийн засгийн бодлого хэрэгслийг юуны түрүүнд дотоод хуримтлал бий болгох, цаашлаад хөрөнгө оруулалтын урт хугацаатай эх үүсвэрийг бүрдүүлэх, улмаар хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд чиглүүлэх замаар гадаад зээлийн хэрэгцээг багасгах; Монгол Улсын түүхий эд, хүн хүчний нөөцийн ашиглалтыг нэмэгдүүлэх замаар дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх бүх талын дэмжлэг үзүүлэх, үүний дотор ажиллах хүчний чадавхыг дээшлүүлэх;

ТТБЗ-өөс өмнө нь өгч байсан дараах санал зөвлөмжүүдийн ач холбогдол хэвээр байна гэж үзлээ.

ХУРИМТЛАЛ ХӨГЖЛИЙН ЭХНИЙ ШАТ

2000 он		М2	ДНБ	Харьцаа
Монгол	сая ам.доллар	236.0	1,115.8	21.1%
Хятад		1,642,349.4	1,211,346.9	135.6%
Япон		11,381,398.5	4,968,359.1	229.1%
Австрали		281,001.9	415,222.6	67.7%
2010 он		М2	ДНБ	Харьцаа
Монгол	сая ам.доллар	3,723.7	7,765.1	48.0%
Хятад		10,721,116.1	6,087,163.9	176.1%
Япон		12,408,311.1	5,759,071.8	215.5%
Австрали		1,154,154.0	1,146,138.5	100.7%
2020 он		М2	ДНБ	Харьцаа
Монгол	сая ам.доллар	8,498.6	13,137.1	64.7%
Хятад		31,121,952.5	14,722,730.7	211.4%
Япон		14,205,628.1	4,975,415.2	285.5%
Австрали		1,824,143.5	1,330,900.9	137.1%

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО

Үзүүлэлт	1995	2005	2015	2019
Нийт хүн ам	2,243.0	2,551.1	3,057.8	3,296.9
15 ба түүнээс дээш насны хүн ам	1,186.5	1,576.8	2,022.6	2,105.6
Ажиллах хүч	812.7	1,001.2	1,243.9	1,273.9
Ажиллагчид	767.6	968.3	1,151.2	1,146.2
Ажилгүй хүн	45.1	32.9	92.7	127.7
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	374.0	575.7	779.0	832.2
Ажиллах хүчний оролцооны түвшин, % (Монгол)	68.5%	63.5%	61.5%	60.5%
Ажиллах хүчний оролцооны түвшин, % (Хятад)	84.0%	78.8%	76.3%	75.9%
Ажиллах хүчний оролцооны түвшин, % (Казакстан)	78.8%	76.4%	77.6%	76.6%

Эцсийн дүндээ боломжийн хуримтлалтай, тогтвортой ажлын байртай эдийн засгийг бий болгосноор төсвийн тогтвортой байдал хангагдана.



Төсвийн тогтвортой
байдлын зөвлөл

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА